



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/679

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08, 2023 оны 13 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан улсын Онцгой комиссын шийдвэрээр аймагт Шуурхай штаб байгуулан тогтмол ажиллуулах болсон тул Шуурхай штабын үйл ажиллагааг тогмолжуулах, мөн Улсын онцгой комиссоос бүх аймагтай хийсэн хуралд ашиглагдах даргын ажлын зураг хэвлүүлэх, хурлыг зохион байгуулах зардал 2,080.000 (Хоёр сая наян мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 2,080.000 (Хоёр сая наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)- т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)- д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ